



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

### Сонгинохайрхан дүүргийн 84 дүгээр цэцэрлэгийн балансаас хөрөнгө шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 3,630,000 /гурван сая зургаан зуун гучин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эд хөрөнгийг 48 дугаар цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн 84 дүгээр цэцэрлэг /Д.Сүрэнхорлоо/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Сонгинохайрхан дүүргийн 48 дугаар цэцэрлэг /Д.Оюунцэцэг/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн 90 дүгээр цэцэрлэг /Д.Сүрэнхорлоо/, 48 дугаар цэцэрлэг /Д.Оюунцэцэг/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Ч.СДНАСАН

15050000100

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2019 оны 03 сарын 01 өдрийн  
АББ тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: СХД-ийн 84 дүгээр цэцэрлэгээс СХД-ийн 48 дугаар цэцэрлэгт

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
						Нэгжийн үнэ	Нийт үнэ			
1	2-р хоолны тогоо	СЭСМ-0.25ЛЧ	2010.09.30	ш	1	3,630,000	3,630,000	3,630,000.0	-	Шилжүүлэх
<b>Нийт хөрөнгийн дүн</b>							<b>3,630,000</b>	<b>3,630,000.0</b>	-	